



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Манхан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/099/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: <a href="mailto:boldbaatarkh@audit.gov.mn">boldbaatarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:<a href="mailto:tsetsegsurena@audit.gov.mn">tsetsegsurena@audit.gov.mn</a> Аудитор: Д.Нямгарав Утас:70432545 Цахим хаяг: <a href="mailto:nyamgaravd@audit.gov.mn">nyamgaravd@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр) .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр) .....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр) .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр) .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр) .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (төгрөгөөр) .....	10
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	10
3.1 Төлбөрийн акт .....	11
3.2 Албан шаардлага .....	11
3.3 Зөвлөмж .....	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл .....	16

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын их хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЦТХ	Цахилгаан түгээх сүлжээ
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



МАНХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Г.ЯДАМЖАВ ТАНАА

ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.08.25 № 118

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Манхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 2,699.0 сая төгрөгийн санхүүжилтээр үндсэн хөрөнгө, 5.5 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч хөрөнгөө нэмэгдүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 бодлого зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 87.0 хувийн гүйцэтгэлтэйгээр сумын Засаг даргаар үйл ажиллагаагаа дүгнүүлсэн байна.

842605023C

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>143,716,543.22</b>	<b>132,594,772.00</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>35,071,624.22</b>	<b>45,050,153.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,832,500.49	1,750,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	26,788,223.73	43,300,153.00
33500	Бусад авлага	6,450,900.00	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	6,450,900.00	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>73,644,919.00</b>	<b>76,974,619.00</b>
35400	Хангамжийн материал	46,917,919.00	50,247,619.00
35420	Аж ахуйн материал	46,917,919.00	50,247,619.00
35500	Биологийн хөрөнгө	1,760,000.00	1,760,000.00
35600	Мал амьтад	24,967,000.00	24,967,000.00
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>35,000,000.00</b>	<b>10,570,000.00</b>
36300	Тэжээлийн нөөц	32,000,000.00	10,570,000.00
36600	Бусад нөөц	3,000,000.00	-
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,763,108,587.77</b>	<b>5,933,224,563.14</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,763,108,587.77</b>	<b>5,933,224,563.14</b>
39200	Биет хөрөнгө	3,670,586,787.77	5,713,271,163.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,328,543,899.99	5,738,066,599.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,232,923,095.68)	(1,472,803,202.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	442,636,940.00	608,706,940.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(307,286,940.00)	(361,800,273.42)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,341,109,415.00	1,356,062,976.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(281,609,436.91)	(466,038,935.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	194,620,641.00	201,306,614.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,006,272.79)	(67,199,176.36)
39209	Зам, гүүрийн байгууламж	863,286,906.00	863,286,906.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(708,962,268.84)	(776,294,285.88)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,000,000.00	5,000,000.00
39217	Ном	65,177,000.00	84,977,000.00
39300	Биет бус хөрөнгө	92,521,800.00	219,953,400.00
39301	Програм хангамж	1,460,000.00	1,460,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,460,000.00)	(1,460,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	92,521,800.00	219,953,400.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>3,906,825,130.99</b>	<b>6,065,819,335.14</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,202,133.79</b>	<b>1,802,800.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,202,133.79</b>	<b>1,802,800.00</b>
41300	Өглөг	2,202,133.79	1,802,800.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	426,033.79	-
41360	Бусад өглөг	1,776,100.00	1,802,800.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,776,100.00	1,802,800.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,904,622,997.20</b>	<b>6,064,016,535.14</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,904,622,997.20	6,064,016,535.14
51100	Засгийн газрын оруулсан капитал	974,241,350.00	974,241,350.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	974,241,350.00	974,241,350.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,941,714,012.77	4,101,107,550.71
51210	Өмнөх үеийн үр дүн	1,374,787,075.54	1,941,714,012.77
51220	Тайлант үеийн үр дүн	566,926,937.23	2,159,393,537.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	988,667,634.43	988,667,634.43
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>3,906,825,130.99</b>	<b>6,065,819,335.14</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,043,064,550.00</b>	<b>3,983,985,544.20</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>959,390,784.00</b>	<b>3,983,985,544.20</b>
120	Нийтлэг татварын бус орлого	959,390,784.00	2,705,178,801.93

Манхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	605,000.00	605,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	871,082,694.00	2,699,028,761.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	87,703,090.00	5,545,040.00
122	Тусламжийн орлого	-	1,278,806,742.27
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,278,806,742.27
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,249,587,800.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	1,249,587,800.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	29,218,942.27
122133	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,100,713.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	472,350.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	16,645,879.27
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,083,673,766.00</b>	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,259,366.00	-
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,242,308.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,322,058.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,695,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,060,414,400.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,060,414,400.00	-
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,476,137,612.77</b>	<b>1,824,312,520.55</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,476,137,612.77</b>	<b>1,824,312,520.55</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,442,929,853.78</b>	<b>1,776,877,021.27</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	683,341,123.00	800,821,593.45
210101	Үндсэн цалин	678,341,123.00	800,821,593.45
210105	Гэрээт ажлын хөлс	5,000,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,166,410.30	98,050,413.97
210201	Тэтгэврийн даатгалын зардал	57,967,035.55	68,069,898.05
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	6,802,143.87	8,003,783.73
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	5,076,409.25	4,001,891.96
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,116,891.53	3,593,195.15
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	11,203,930.10	14,381,645.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,830,261.01	135,802,900.00
210301	Гэрэл, цахилгаан	11,308,861.01	14,298,600.00
210302	Түлш, халаалт	71,521,400.00	120,704,300.00
210303	Цэвэр, бохир ус	-	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	67,671,088.00	21,726,485.00
210401	Бичиг хэрэг	3,754,300.00	3,521,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,250,898.00	13,645,435.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,011,050.00	3,548,700.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	38,654,840.00	1,011,350.00

**Манхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

2105	Нормативт зардал	531,600.00	285,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	531,600.00	285,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,972,200.00	1,087,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	316,200.00	187,000.00
210604	Урсгал засвар	1,656,000.00	900,200.00
2107	Томилолт, зочны зардал	7,662,000.00	8,792,200.00
210702	Дотоод албан томилолт	7,662,000.00	8,792,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,528,755.00	20,686,738.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,787,175.00	18,320,078.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,500.00	519,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	225,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	392,360.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	311,000.00	400,000.00
210807	Газрын төлбөр	282,080.00	830,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	506,226,416.47	689,624,490.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,486,305.00	106,473,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,390,000.00	2,500,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	437,350,111.47	580,651,290.85
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,207,758.99</b>	<b>47,435,499.28</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	46,035,499.28
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	46,035,499.28
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	46,035,499.28
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	46,035,499.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,785,305.00	1,400,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,872,805.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,912,500.00	1,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,422,453.99	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,422,453.99	-
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>566,926,937.23</b>	<b>2,159,673,023.65</b>
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>279,485.71</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	279,485.71
VII	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	-	<b>(279,485.71)</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>566,926,937.23</b>	<b>2,159,393,537.94</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,094,485,866.00	1,306,199,966.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	605,000.00	1,306,199,966.00
120	Нийтлэг татварын бус орлого	605,000.00	605,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	605,000.00	605,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
122	Тусламжийн орлого	-	1,305,594,966.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,305,594,966.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,249,587,800.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	1,249,587,800.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	56,007,166.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,100,713.00

Манхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	472,350.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	43,434,103.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,093,880,866.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,466,466.00	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,242,308.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,322,058.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,902,100.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,060,414,400.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,060,414,400.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,046,421,466.00	1,251,199,966.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,046,421,466.00	1,251,199,966.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	994,744,869.01	1,160,464,313.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	676,575,800.00	801,753,273.25
210101	Үндсэн цалин	373,487,039.00	389,522,947.47
210102	Нэмэгдэл	240,285,816.00	323,325,855.00
210104	Урамшуулал	23,202,945.00	31,545,492.78
210105	Гэрээт ажлын хөлс	39,600,000.00	57,358,978.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,572,200.00	97,462,267.47
210201	Тэтгэврийн даатгалын зардал	57,508,900.00	69,039,073.49
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	6,765,900.00	6,659,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	5,138,200.00	3,329,600.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,627,700.00	3,329,600.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	13,531,500.00	15,104,693.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,954,761.01	135,802,900.00
210301	Гэрэл, цахилгаан	12,933,361.01	14,298,600.00
210302	Түлш, халаалт	74,021,400.00	120,704,300.00
210303	Цэвэр, бохир ус	-	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,648,248.00	20,677,150.00
210401	Бичиг хэрэг	3,087,900.00	3,595,200.00
210402	Тээвэр, шатахуун	18,199,298.00	13,533,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,361,050.00	3,548,700.00
2105	Нормативт зардал	553,700.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,230,800.00	1,150,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,000.00	306,500.00
210604	Урсгал засвар	2,913,800.00	844,200.00
2107	Томилот, зочны зардал	7,662,000.00	8,792,200.00
210702	Дотоод албан томилот	7,662,000.00	8,792,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,731,680.00	18,038,273.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	16,386,600.00	15,562,013.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,500.00	519,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,500.00	225,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	392,360.00

**Манхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	867,000.00	509,600.00
210807	Газрын төлбөр	282,080.00	830,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,815,680.00	76,787,550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,331,680.00	74,287,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,484,000.00	2,500,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,676,596.99	90,735,652.28
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	89,335,652.28
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	89,335,652.28
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүү	-	89,335,652.28
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн	-	46,035,499.28
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөр	-	43,300,153.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,785,305.00	1,400,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан	28,872,805.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,912,500.00	1,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,891,291.99	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,422,453.99	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	18,468,838.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	48,064,400.00	55,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	48,064,400.00	55,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,064,400.00	55,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	48,064,400.00	55,000,000.00
220001	Барилга байгууламж	-	20,000,000.00
221001	Их засвар	-	15,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	20,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	48,064,400.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(48,064,400.00)	(55,000,000.00)
VIII	ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** (төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	974,241,350.0	992,076,393.43	1,375,957,112.94	3,342,274,856.37
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,170,037.40)	(1,170,037.40)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	974,241,350.0	992,076,393.43	1,374,787,075.54	3,341,104,818.97
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(3,408,759.00)	-	(3,408,759.00)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	566,926,937.23	566,926,937.23
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	974,241,350.0	988,667,634.43	1,941,714,012.77	3,904,622,997.20
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	974,241,350.0	988,667,634.43	1,941,714,012.77	3,904,622,997.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	974,241,350.0	988,667,634.43	1,941,714,012.77	3,904,622,997.20
19	Тайлант үеийн үр дүн	-	-	2,159,393,537.94	2,159,393,537.94

Манхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	974,241,350.0	988,667,634.43	4,101,107,550.71	6,064,016,535.14
----	--	---------------	----------------	------------------	------------------

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,123,755,400.00</b>	<b>1,204,157,300.72</b>
12	Татварын бус орлого	1,123,755,400.00	1,204,157,300.72
120	Нийтлэг татварын бус орлого	605,000.00	605,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	605,000.00	605,000.00
122	Тусламжийн орлого	1,123,150,400.00	1,203,552,300.72
122005	Төсвөөс санхүүжих	1,123,150,400.00	1,203,552,300.72
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,243,087,800.00</b>	<b>1,204,157,300.72</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,188,087,800.00</b>	<b>1,149,157,300.72</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,186,071,800.00</b>	<b>1,147,757,300.72</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	814,034,600.00	801,753,273.25
210101	Үндсэн цалин	401,602,100.00	389,522,947.47
210102	Нэмэгдэл	323,428,000.00	323,325,855.00
210104	Урамшуулал	31,545,500.00	31,545,492.78
210105	Гэрээт ажлын хөлс	57,459,000.00	57,358,978.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,754,200.00	97,462,267.47
210201	Тэтгэврийн даатгал	69,192,900.00	69,039,073.49
210202	Тэтгэмжийн даатгал	8,140,400.00	6,659,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,070,100.00	3,329,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,070,100.00	3,329,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,280,700.00	15,104,693.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	135,803,100.00	135,802,900.00
210301	Гэрэл, цахилгаан	14,298,600.00	14,298,600.00
210302	Түлш, халаалт	120,704,500.00	120,704,300.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,740,000.00	19,610,150.00
210401	Бичиг хэрэг	3,100,500.00	2,720,200.00
210402	Тээвэр, шатахуун	18,893,500.00	13,341,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,746,000.00	3,548,700.00
2105	Нормативт зардал	683,200.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	683,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,101,100.00	1,150,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	494,600.00	306,500.00
210604	Урсгал засвар	1,606,500.00	844,200.00
2107	Томилолт, зочны зардал	9,543,300.00	8,792,200.00
210702	Дотоод албан томилолт	9,543,300.00	8,792,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,499,400.00	16,170,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,826,900.00	13,694,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	519,000.00	519,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,000.00	225,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	552,000.00	392,360.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	546,200.00	509,600.00
210807	Газрын төлбөр	830,300.00	830,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,912,900.00	67,015,550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,912,900.00	64,515,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	2,500,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,016,000.00	1,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,016,000.00	1,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,016,000.00	1,400,000.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>55,000,000.00</b>	<b>55,000,000.00</b>

220001	Барилга байгууламж	20,000,000.00	20,000,000.00
221001	Их засвар	15,000,000.00	15,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	20,000,000.00	20,000,000.00
8	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(119,332,400.00)</b>	-
9	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>119,332,400.00</b>	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	119,332,400.00	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>56,007,166.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>56,007,166.00</b>
122	Тусламжийн орлого	56,007,166.00
1221	Хандив тусламж /дотоод/	56,007,166.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,007,166.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,100,713.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	472,350.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,434,103.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>12,707,013.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>12,707,013.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>12,707,013.00</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	1,067,000.00
210401	Бичиг хэрэг	875,000.00
210402	Тээвэр, шатахуун	192,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,868,013.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,868,013.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,772,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,772,000.00
4	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>43,300,153.00</b>
5	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(43,300,153.00)</b>
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(43,300,153.00)

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18,841.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 406.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- 2025 онд ХИНЦ хоршооноос данс андуурч 127.4 мянган төгрөгийн зээлийн төлбөрийг өөрийн орлогоос хасаж тооцоогүй,
- Үндсэн хөрөнгийн гарз дансанд 279.5 мянган төгрөгийг тусгаагүй байна.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

<sup>1</sup> Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна

Залруулагдаагүй нийт 41,623.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс “бага” байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 18,434.9 мянган төгрөгийн 8 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1,169.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага өгч, 16,815.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

#### 3.1.1 Цалин, томилолттой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын тэмцээнд оролцсон албан хаагчдад сумын Засаг даргын захирамж, тамгын газрын даргын тушаалаар үр дүнгийн урамшуулал олгохдоо 2025 оны 3, 4-р улирлын урамшуулалттай давхардуулан 1,619.1 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн нь санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Албан шаардлага

#### 3.2.1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс хандив, туршлага судлах, тэмцээний хувцас хийлгэх, бооцоо, мөн анхан шатны баримт бүрдэл болоогүй баримтаар үйл ажиллагааны зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1-т “Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна”, 7 дугаар зүйлийн 7.1-т “Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна” гэж заасныг тус тус зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй, таслан зогсоохоор хугацаатай албан шаардлага өгсөн.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **3.3.1 Бүтэц, орон тоотой холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тус байгууллага нь 2025 онд аймгийн Засаг даргын 2023 оны А/201 тоот захирамжаар баталсан бүтэц орон тооноос чиг үүрэг нь давхардсан 1 орон тоог илүү ажиллуулж, түүнд 12,624.0 мянган төгрөгийн цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д “чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан орон тоогоор ажиллах.

#### **3.3.2 Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2025 оны нийгмийн даатгалын тайлангийн үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, Баянгол багийн сахиул нь 22001 кодтой өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байтал цалингаас нь нийгмийн даатгалын шимтгэлийг 01 кодоор тооцон төлсөн зэрэг нийт 797.8 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн дагуу суутган тооцож, бүртгэлд үнэн зөв тусгах

#### **3.3.3 Гэрэл цахилгааны зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2025 онд 16,001.3 мянган төгрөгийн бичилтээс 14,298.6 мянган төгрөгийн цахилгааны зардлыг харилцахаар төлсөн, үлдэгдэл 1,537.8 мянган төгрөгөөс 1,200.0 мянган төгрөгийг гэрлийн байцаагчаар төлүүлсэн, үлдэгдэл 354.0 мянган төгрөгийг тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын өр авлагыг иж бүрэн баримтыг үндэслэн тооцож, бүртгэлд үнэн зөв тусгах.

#### **3.3.4 Тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тус байгууллагын дансанд бүртгэлтэй хогны машиныг иргэнд түрээслүүлэхдээ түрээсийн гэрээ байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн гэрээг хуулийн дагуу байгуулж, байгууллагын үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх.

### **3.3.5 Нөөцийн бараатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2025 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг даргын тамгын газрын 3,850.0 мянган төгрөгийн өвсний үлдэгдлийг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өвсний тооцоог үнэн зөв бодож, аймгийн Засаг даргын тамгын газартай тооцоо нийлэх.

### **3.3.6 Дотоод хяналт, хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2025 оны 11 дүгээр сард хийсэн завсрын аудитаар тус байгууллагын эзэмшлийн Ниссан патрол авто машиныг цэнхэр дугаартай болох гэсэн зөвлөмжийг өгсөн бөгөөд одоо хүртэл цэнхэр дугаар аваагүй буюу өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тээврийн хэрэгсэлд цэнхэр дугаар авч хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
2025 онд ХИНЦ хоршоо нь данс андуурч 127,397 төгрөгийн зээлийн төлбөрийг өөрийн орлогоос хасаж тооцоогүй	1	127.4			1	127.4	1	127.4		
Үндсэн хөрөнгийн гарз дансанд 279,495.71 төгрөгийг тусгаагүй	1	279.5	1	279.5			1	279.5		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>406.9</b>	<b>1</b>	<b>279.5</b>	<b>1</b>	<b>127.4</b>	<b>2</b>	<b>406.9</b>		

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2025 онд жолооч-нярав гэсэн орон тоог баталсан боловч чиг үүрэг давхардсан орон тоогоор буюу 2 жолооч ажиллуулсан	1	12,624.0					1	12,624.0
Спорт тэмцээнд оролцсон албан хаагчид сумын Засаг даргын захирамж, тамгын газрын даргын тушаалаар үр дүнгийн урамшуулал олгохдоо 2025 оны 3, 4-р улирлын урамшуулалттай давхар олгосон	1	1,619.1	1	1,619.1				
2025 оны нийгмийн даатгалын тайлангийн үлдэгдлийг 562,431.81 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, Баянгол багийн сахиул нь 22001 кодтой өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байтал цалингаас нь нийгмийн даатгалын шимтгэлийг 01 кодоор тооцон төлсөн	1	797.8					1	797.8
Гэрэл цахилгааны зардалд 2025 онд 16,001,298.70 төгрөгийн бичилтээс 14,298,600 төгрөгийг харилцахаар төлсөн, үлдэгдэл 1,537,779.72 төгрөгөөс 1,200,000 төгрөгийг гэрлийн	1	354.0					1	354.0

Манхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

байцаагчаар төлүүлсэн, үлдэгдэл 354,005.32 төгрөгийг тайланд тусгаагүй								
Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль зөрчиж хандив, туршлага судлах, тэмцээний хувцас хийлгэх, бооцоо, мөн анхан шатны баримт бүрдэл болоогүй баримтаар зарим үйл ажиллагааны зардалд зарцуулсан	1	-			1	-		
2025 оны 7-р сараас сумын Тамгын газарт бүртгэлтэй хогны машиныг иргэнд түрээслүүлэхдээ түрээсийн гэрээ байгуулаагүй	1	150.0					1	150.0
2025 оны жилийн эцсийн байдлаар өвсний тооцоо 2,890,000 төгрөгийг барагдуулаагүй, тооцоо нийлээгүй	1	2,890.0					1	2,890.0
Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй /Ниссан патрол авто машины цэнхэр дугаартай болгох/	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>18,434.9</b>	<b>1</b>	<b>1,619.1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>6</b>	<b>16,815.8</b>

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			